

ARTICLE

**“Жийжүү хот” хэмээх монгол ардын богино дуунд хийсэн үйл явдал, утгын  
ажиглалт**

*Бай хун мэй<sup>1\*</sup>*

*Монгол Улс, Улаанбаатар,  
Монгол Улсын Боловсролын  
Их Сургууль, Дүрслэх урлаг,  
технологийн сургууль  
Email: 450488339@qq.com*

*Эрдэнэбаатар ЦЭЛМЭГ<sup>1</sup>  
Монгол Улс, Улаанбаатар,  
Соёл Урлагийн Их Сургууль,  
Хөгжмийн урлагийн сургууль  
Email: [80863737@gmail.com](mailto:80863737@gmail.com)*

**Received:** September 20, 2025 | **Accepted:** December 17, 2025 | **Published:** December 30, 2025

**Хураангуй:** Тус өгүүлэлд монгол ардын “Жийжүү хот” хэмээх дууны төрөл зүйл, үг шүлэгт ажиглалт хийх, зарим үгийн утгыг хэл-соёлын артефактын үүднээс тайлбарлах замаар бичвэрийн утга, эмэгтэй хүний дүрийг нарийсган тодруулахыг зорьсон байна. Мөн С.Карпманы онолын үүднээс “Жийжүү хот” хэмээх монгол ардын дуу нь харилцаа дуу гэхээсээ ганц хүний дуулдаг жүжиглэлт хэлбэр байж болохыг тодруулахыг хичээсэн байна. Зохиогчид өгүүлэлдээ аман зохиолын хэл, бичвэр зүй, түүхэн зүйн хандлага, бэлгэдлийн болон феноменологийн онол, арга зүйг ашиглажээ. “Жийжүү хот” дуу нь хэдийгээр хайр сэтгэлийн зөрчил бүхий гурван субъект оролцсон дуу боловч монгол эмэгтэй хүний үнэнч, ариун, нарийн ухааныг хэрхэн илэрхийлснийг дууны бичвэр дэх үгст тайлбар хийх замаар нарийсган харуулсан байна.

Зохиогчид, уг дууны Монгол Улс, БНХАУ-ын ӨМӨЗО-д хэвлэгдсэн цахар, хорчин зэрэг хувилбаруудыг харьцуулан үзээд тус дууны Гэсэр баатартай холбоотой бадгууд хасагдаж, дуулагдахаа больж байгааг анхааруулжээ.

**Түлхүүр үг:** Монгол ардын богино дуу, домогт дуу, түүхэн сэдэвт дуу, харилцаа дуу, хэл-соёлын артефакт

<sup>1</sup> ©, Зохиогч(ид), 2025; \* - Холбоо барих зохиогч

## Plot and Semantic Analysis of the Mongolian Folk Song “Jijüü Khot”

BAI HONG MEI

School of Fine Arts and Technology,  
Mongolian National University of Education, Ulaanbaatar, Mongolia

QILEMUGE Erdenebaatar

School of Music Arts,  
Mongolian National University of Arts and Culture,  
Ulaanbaatar, Mongolia

**Abstract:** *The purpose of this article is to explain the meaning of the Mongolian folk song ‘Jijuu Hot’ and the image and psychology of women in it, analyse the genre and lyrics of the song, and explain the meaning of some words in terms of linguistics and cultural artefacts. Drawing on S. Karpman’s theory of the dramatic triangle, the authors suggest that the Mongolian folk song “Jijuu Hot” can be regarded as a form of solo performance rather than a duet song. The analysis integrates theories of folklore, textuality, phenomenology, and symbolism, and is conducted through historical and semiotic methodologies. Although the song ‘Jijuu Hot’ is a song involving three conflicting subjects of love, it shows how the loyalty, purity, and delicacy of Mongolian women are expressed through the interpretation of the song’s lyrics and some cultural artefacts. The authors compare versions of the song published in Mongolia and the Inner Mongolia Autonomous Region of China, such as Tsahar and Horchin, and point out that the verses associated with the hero Geser in the song have been removed and are no longer sung.*

**Keywords:** *Mongolian folk songs, mythological songs, historical songs, duet song, linguistic and cultural artefacts*

### Удиртгал

Аман яруу найргийн бичвэрийг агуулж буй бүхий л элемент болох хэлний хэвтээ ба босоо тэнхлэгийн түвшин, хэлний бус гүн давхаргуудын нягт харилцаа бүхий цогц нийлэмж гэж үздэг. Тиймээс “Бичвэрийн гүн давхарга нь тухайн бичвэрийн феноменологийн өгөгдөл, ялангуяа артефактуудын давхаргаар идэвхэждэг хэлний ба хэлний бус давхаргаас ихээхэн хамааралтай” (Штайн 2000, 59) байна.

Феноменологийн онолыг үндэслэгч Эдмунд Гуссерлийн аргыг 1920-1930-аад онд утга зохиолын шүүмжлэлд анх ашигласан нь аажимдаа аман зохиолын бичвэр зүйн судалгаанд нөлөөлсөн юм. Утга зохиолын шүүмжлэгчид хэлний феноменологийг ашиглахдаа бичвэрээр дамжин илэрч байгаа хүний ухамсарт (гадаад, дотоод)-голлон анхаарах бол, аман зохиол судлаачид уран сайхны илэрхийлэл, мөн танихуй, бэлгэдлийн утгад анхаарлаа хандуулдаг.

Бичвэрийн ээдрээтэй бүтцийн хэлний бус давхаргад аман бүтээлийн (уран зохиол) угтал тайлбар, нөхцөл байдлыг илэрхийлэх дүрслэл, төрөл зүйл, тэрчлэн артефакт, фрейм тэргүүтэн ордог. Монгол ардын урт болон богино дууны олонд нь морины тухай юм уу, эсвэл байгалийн дүрслэлээр эхэлдэг үндсэн гэж болох онцлогтой.

Урлагийн судалгаанд артефакт гэдэг хөгжмийн хамсрал бүхий дууны бүтээл объективчлогдсон зүйл болохыг тогтоосон (Волек, 1986: 276) бол ардын дуу, уянгын бүтээл хэсэгчилсэн субъектив артефактын тухай ойлголт гарч ирнэ. Тиймээс артефакт үргэлж бодитой зүйл байдаггүй, “хүний уран сайхны хэрэглээ, туршлагын импульсийг өдөөгч чанар нь тухайн урлагийн бүтээл оршин тогтнох, бодитжин биелэхэд (дууны бүтээл ном, клип, цомог болох, ухамсарлах г.м) нөлөөлдөг бодит байдал” (Волек, 1986: 279) ажээ.

Ялангуяа харилцан яриа, харилцаа дуу бол яригч-сонсогч, харилцан дуулагчдын хооронд өрнөж байгаа үйл явдал, бичвэр нь өөрөө артефакт болно. Нөгөө талаар аман зохиолын бичвэрийн нэг ардын дуунд, тусгалаа олсон эд өлгийн зүйлс нь урлагийн системд танихуйгаар илэрхийлэгдэж, бодитжуулсан төсөөлөл буюу дүрслэлийн рефлексив үйл ажиллагаа болж илрэх ажээ. Өөрөөр хэлбэл, ардын дууны бичвэр дэх эд өлгийн зүйлийг танин мэдэхүйгээр шууд идэвхжүүлэх, эсвэл далд аргаар идэвхжүүлж болох тухай судлаачид бичжээ (Штайн., Петренко, 2011: 668).

Америкийн эрдэмтэн М.Вартофский бичвэрийн үндэс нь гүний загвар, буюу гүнзгий хэв шинж (стереотип) дээр суурилдаг бөгөөд ялангуяа урлагийн бүтээл (аман бүтээл) нь ертөнцийг өөрийн танин мэдэхүйгээр нэг ёсондоо “өмчлөх” нэг хэлбэр гэжээ (Вартофский, 1988: 8).

#### **Судалгааны таамаглал:**

1. Аман соёлын хүрээнд артефакт нь тухайн аман бүтээлийн бичвэр дэх эд юмсын дүрслэлээр илэрч байгаа утгын судалгаа гэж тайлбарлаж болно. Хүн төрөлхтөн аж байдал, ахуй, өөрийн хэрэгцээндээ ашиглах зорилгоор эд өлгийн зүйл үйлдвэрлэх нэг хэрэг, тэдгээрийг дууны бичвэрт дурдан оруулж байгаа нь хэлний “дүрслэлийн үйлдвэрлэл” бөгөөд тэдгээр эд юмс дахин өөр утгыг олж, тэдгээрийг ямар утгаар сонгон оруулав гэдгийг бэлгэдэл зүй, хэлний артефактын зүгээс тайлбарлах нь чухал юм.

2. Тус дуунд дүрслэгдэж байгаа эд зүйл нь хүний дотоод сэтгэл, далд ухамсрыг илэрхийлэх хэлний бус давхарга дахь бэлгэдлийн артефактууд болно.

3. Монгол ардын богино дуу “Жийжүү хот” дууг С.Карпманы драмын гурвалжнаар тодруулах замаар үйл явдал, зохиомж, бүтцийг тодорхойлж болно.

Таамаглалыг батлахын тулд “Жийжүү” хот хэмээр ардын богино дууны зарим үгэн дэх артефакт дүрслэл бүхий үгэнд тайлбар хийх замаар хүмүүсийн харилцаа, сэтгэлийн дотоод илэрхийлэл, зан авир, ёс суртахууны хандлагыг монголчуудын бэлгэдэлт сэтгэлгээ, дуун дахь соёлын агуулгатай холбон тайлбарлах зорилго тавьсан болно.

**Судлагдсан байдал:** “Жийжүү хот” дуу монгол үндэсний дотор өргөн дэлгэрсэн бөгөөд халх, цахар, үзэмчин, барга, Алашагийн монголчууд тэрчлэн

хорчинчуудын дунд дуулагдаж, дууны эмхэтгэл түүвэрт олонтоо хэвлэгджээ. Хамгийн анх Монгол улсад 1935 онд хэвлэгдсэн түүхтэй бол бидний тооцоогоор Монгол Улсад 10 шахам удаа, Өвөр монголд 5-6 удаа хэвлэгдсэн байна.

Тус дуу нь хэлбэр, зохиомжийн хувьд сонирхолтой, дан болон харилцаа дууны аль ч төрөлд хамаарах, агуулгын хувьд, хошин болон гунигт шинжтэй, зорилгоороо тайлга тахилгын буюу зан үйлийн учир зориулалттай, түүнчлэн түүхэн сэдэвт дуунд ч хамаарагдах боломжтой тул судлаачид янз бүрийн байдлаар тодорхойлжээ.

Дууны түүхэн үндсийг хэд хэдэн судлаачид тодруулах эрэл хайгуул хийсэн байна. 2017 онд Тус дууны талаар сэтгүүлч, доктор Лх.Мөнхтөр Монголын олон нийтийн үндэсний радиогийн «Ардын хөгжмийн сан»-гаар «Жийжүү хот» ардын дууны домгийн талаар нэвтрүүлэг бэлтгэсэн нь мөн оны 3 дугаар сарын 03-нд нэвтэрсэн билээ. Тус нэвтрүүлэгт уг дууны түүхийг «1700-аад оны үед Тэрхийн голын сав нутаг, Тариат уулын бэлд Далай Чойнхор вангийн хошуунд алт, мөнгөний урлал ихэд хөгжиж, ялангуяа зээгт наамал, уран хатгамлаараа бусад нутаг хошуудад алдаршиж эхэлсэн байна» гээд тус Вангийн хүрээний тахилч Гүнтэв хэмээх эр хүрээний уран хатгамалч Дэнсий юу хэмээн уран, ганган хүүхэнтэй амрагийн холбоотой болсон түүхээс үүдэн гарсан домогт дуу гэж үзсэн байна. Энд өөр нэг үндэслэл байдаг нь ардын дуу судлаач Д.Баасанжав гуай, Сайн ноён хан аймгийн Далай Чойнхор вангийн хошуу буюу одоогийн Архангай аймгийн Тариат сумын Гэсэр сүмийн оёдолчин Дэнсээцогзол, Гэсэр сүмийн тахилч асман лам Түвдэн нарын хайр сэтгэлийн дуу «Жийжүү хот»-оос санаа авч «Дэнсий юу» гэх дууны үгийг зохиосон гэдэг сэжмийг өгүүлжээ.

Өвөр Монголын Цахарын соёл судлалын нийгэмлэгийн Өвөр Монголын их сургуулийн докторант Б.Буянзаяа, МУИС-ийн магистрант Б.Гэрэлмаа нар сэтгүүлд “«Жийжүү хот» хэмээх дууны судалгааны зарим асуудал” нэртэй өгүүлэлдээ дээрх домгийг хүлээн зөвшөөрөх хандлагатай байгаа бөгөөд ӨМӨЗО-ы Шилийн гол аймгийн цахарт дуулагддаг хувилбарыг дууны ая аялгууны талаар авч үзсэн байна. Өвөр Монголд үүнээс өөр судалгаа байхгүй байна.

Иймд бид тус дууны домог түүхэн үнэнд аль хэр дөхүү болох, төрөл зүйлийн хувьд хэрхэн авч үзэх талаар өөрсдийн судалгаа, тодруулгыг хийлээ.

**Судалгааны арга:** Драмлаг шинжтэй ардын дууны үйл явдлыг хөөх замаар дүрийг тодруулахад аман зохиолын эх бичвэр зүй, үгийн утгын тайлбар-утгазүйн үндсэн аргууд, бэлгэдэл зүй, соёлын артефакт судалгаа, угсаатны зүй, түүх-соёлын нөхцөл байдлыг шинжлэх аргуудтай хослуулан ашигласан болно.

**Судалгааны үр дүн:** Аман соёлын хүрээний артефакт нь тухайн аман бүтээлийн бичвэр дэх эд юмсын дүрслэлээр илэрч байгаа утгын судалгаа гэж таамаглаж байгаа тул юуны өмнө “Жийжүү хот” хэмээх дууны бичвэрт тодорхой ажиглалтуудыг хийлээ.

Тус дуу нь Монгол Улсад нэлээд түүвэрт орж хэвлэгджээ. Тухайлбал,  
1. “Монгол дуунуудын түүвэр”. Нотын хамт. Ардыг гэгээрүүлэх яамны хэвлэл, Монгол Улсын хэвлэлийн хороо (Хорин тавдугаар он /1935, 14 дүгээр дуу).  
2. “Монгол ардын дуунууд” (1957, х.31),  
3. Э.Оюун “Монгол ардын харилцаа дууны зүйлээс” (1960, х.314),

4. Монгол ардын мянган дуу. II. Эмхэтгэсэн Д.Цэрэндаш (1992, х. 53-54)
5. Монгол ардын дуунууд (1957, х. 29-30)
6. С.Гончигсумлаа “Монгол ардын гучин дуу” (1976, х.58).
7. “Монгол ардын хошин шог дуу”. Эмхэтгэсэн Х.Дашзэгвэ (1998, х.136-138).
8. “Монгол ардын дуу” (2003, х.80).
9. Зуун лангийн жороо луус. Эмхэтгэсэн Г.Балданцэрэн (2005, х.66-67)
10. Монголын үндэстэн ястны ардын 1008 дуу. Эмхэтгэсэн Ш.Даваахүү (2014, х.794-795)

БНХАУ-ын ӨМӨЗО-д хэвлэгдсэн ардын дууны түүврүүдэд тус дууны текст байгаа ч Монгол Улсад хэвлэгдсэн хувилбаруудаас бараг зөрөөгүй шахам байна.

“Жийжүү хот” дууны хамгийн анхны бичвэр Монгол Улсын Ардыг гэгээрүүлэх яам ба Уран сайхны улс төрийн зөвлөлөөс санаачилсан “Mongyul daγuu-niyud-un tegübügi” хэмээх 98 дуутай дууны анхдугаар түүвэрт багтсан бөгөөд уг дууг Магсар хурцын Дугаржав гуай дуулж оруулжээ. Энд “Жийжүү хот” дууг тав болон зургаагаар шадалсан 4 бадаг орсон байх ба харилцаа биш дан хэлбэртэй хэвлэгдэхдээ:

1. Жийжүү хотын жинтэй<sup>2</sup> торгоор  
Жинтүүний буланг шагласан юм хө хө  
Минь хө  
Жинлүн буу дин<sup>3</sup>, хасын ордон хоёрыг  
Жинхэнэ янзаар дууриалгаад оёсон юм аа
2. Урд газрын хоо<sup>4</sup> ягаан торгоор  
Уутны буланг шагласан юм хө хө  
Утай<sup>5</sup> Будалан<sup>6</sup> дагшин таван орныг  
Уултай устай нь шагласан юм хө хө  
Минь хө
3. Баруун голын усанд нь ольё оо гэсэн юм хө хө  
Банз модоор дамнуурга тавьсан юм хө хө  
Ба та луу чин<sup>7</sup>, Баатар жанжин хоёрыг  
Байлдуулж барилдуулаад шагнасан юм хө хө  
Минь хө
4. Бээжин хотын бэнтэй<sup>8</sup> торго  
Биед нь бэлэг болгоод барьсан юм хө хө  
Минь хө

<sup>2</sup> хятад. Жин -錦 буюу цинь, угалзан хээтэй торгоны зүйл

<sup>3</sup> хятад. Жинлүн буу дин-Алтан луут эрдэнийн ордон

<sup>4</sup> Монгол. хоо-ухаа

<sup>5</sup> Утай- Хятадын Шаньси мужийн зүүн хойд хэсэгт байдаг Утай уул, тус уулаар нэрлэгдсэн бурхны шашны төв. Уг үг нь тэгш оройт таван уул гэсэн утгатай.

<sup>6</sup> Буталан-Потала ордон (Төвөд.: ཡུལ་ལོ་) нь Хятад улсын Төвөдийн өөртөө засах орны Лхас хотод байрладаг ордны нэр, буддын шашны сүмийн цогцолбор юм.

<sup>7</sup> хятад. Ба та луу чин-Э.Оюуны (1960) хэвлүүлсэн хувилбарт “Баадай, Луудай баатар жанжин хоёрыг” гэж буй (Оюун, 1960, 314).

<sup>8</sup> хятад. бэн-зоос мөнгө

Би тан би тан<sup>9</sup>, багир<sup>10</sup> эрдэнэ ордныг  
Жин лунг<sup>11</sup> ороогоод урлан шагласан юм хө хө  
Минь хө гэсэн үгтэй байгаа бөгөөд нэлээд тооны хятад гаралтай монгол болон хятад хэлэнд ойлгомжгүй болсон үг цөөнгүй байна.

1957 оны “Монгол ардын дуунууд” түүвэрт 4 бадгаар, дан дууны хэлбэрээр орсон бол Э.Оюуны “Монгол ардын харилцаа дууны зүйлээс” номд харилцаа дууны хэлбэрээр хамгийн олон бадгаар хэвлэгджээ. Харин сүүлийн үеийн эмхэтгэл түүврүүдэд өмнөх хэвлэлийн бичвэрийг шууд хуулбарлах, хуулбарлахдаа үг үсгийг зөрүүлэх зэрэг алдаа мадагтай оруулсан байна. Тухайлбал, 2005 онд хэвлэгдсэн “Монгол ардын домогт харилцаа дуу” (Соёмбо принтинг) хэмээх номд Э.Оюуны “Монгол ардын харилцаа дууны зүйлээс” номоос хуулбарлан оруулахдаа *жин байшин-жинь байшин, Баадай, Луудай-Баадай, жуудай баатар, Цалман амтай-Цайлган амтай* (10-11 дэх тал) гэх мэт зөрүүлэн бичжээ.

Дууны хувилбаруудаас Х.Дашзэвэгийн эмхэтгэл хэвлүүлсэн “Монгол ардын хошин шог” дууны түүвэрт Гэсэр болон Цасчихэр нарыг дурдсан хувилбарыг оруулснаараа онцлог юм. Энэ нь,

...Цагаан жигүүртэй тахиа шувууг

Цааш, нааш нь харуулж байгаад шаглаад оёсон юм

Цагаавтар царайтай Цасчихэр баатрыгаа

Цааш нааш нь харуулж байгаад урлаад оёсон юм

Улаан жигүүртэй тахиа шувууг

Урагш, хойшоо донгодож байгаагаар шаглаад оёсон юм

Улаа бутарсан царайтай Гэсэр мэргэн баатрыгаа

Урагш хойш нь харуулж байгаад урлаад оёсон юм (Дашзэвэг, 1998: 136) гэж Гэсэр хааны ах Цасчихэр, Гэсэр мэргэнийг тус тус дурдсан нь өөр богино дунд олон гардаггүй бөгөөд энэ дууны түүхэн шинжийг тодруулж байна.

Эмхэтгэл түүврийн олонход дан дууны маягаар хэвлэгдсэн байна. Тэгвэл, харилцаа дуу гэхийн учир нь уг дуунд Дэнз’яа (Дэнзиймаа) хүүхэн, Бянлуу хүүхэн, Хархүү гурвын хайр сэтгэлийн зөрчлийг харуулдаг.

Уг дуу нь Дэнз’яа хүүхэн сайхан торгоор жинтүү, уутыг чимэглэн урлаж байгаагаа өгүүлж эхлэх ба Бянлуу хүүхэн, Дэнзьяагийн залууд хандан “Цаанаа ханьтай чамайг царайчилж суудаг нь миний буруу яа” гэж эхэлж байгаагаас үзвэл Дэнзьяа, Хархүү хоёр гэр бүл ажээ. Харин Хархүү,

Арилгасан сонгино шиг арван хуруугаар

Аялгуут шанзыг дарах нь аятайхан байна!

Амраг хөөрхөн ааш чинь болбол

Аюулхай зүрхий минь догдлуулаад байна!

Үрээ морио уная даа гэсэн чинь

Үргэж булгаад горьгүй байна

Өөрийн хайртай Бянлуу чамдаа очьё гэсэн чинь

<sup>9</sup> хятад. би тан би тан-ногоон ордон, танхим


<sup>10</sup> багир-бөөн цул

<sup>11</sup> хятад. Жин лунг -алтан луу

Үерхэж суусан Дэнз'яа минь уурлаж загнаад байна! гэж Бянууугай уулзаж чадахгүй байгаагаа учирлахад Бянуу хүүхэн түүнийг гэр бүлтэйг мэдсээр байж ирж уулзахыг шаардах “тэр морь, эхнэр хоёроо сайтар сурга” гэж Хархүүг ухуулах гэж оролдоно.

Дууны үйл явдлыг Карпманы<sup>12</sup> драмын гурвалжны онолоор,

Зураг 1. Stephen B. Карпман-ы драмын гурвалжин



Эх сурвалж- <https://karpmandramatriangle.com/pdf/DramaTriangle.pdf>-аас сэдэвлэв.

авч үзвэл “хохирогч” нь Дэнзьяа бүсгүй, “дарангуйлагч” буюу “хохироогч” нь Бянуу хүүхэн, түүнтэй нийлсэн Дэнзьяагийн нөхөр хоёр болж таарна. Харин “аврагч” (дүр) тодорхойгүй байгаа юм.

Бид, 1987 онд Өвөр монголын “Монгол тулгуур бичгийн цуврал” (Аман зохиол)-аар хэвлэгдсэн “Хорчин ардын дуу” номын хоёрдугаар ботид буй 1975 онд Жирэм аймгийн Дархан хошууны хуурч Сүве Зү-гээс тэмдэглэж авсан “Гоо Шио Жэй” гэх дуутай “Жийжүү хот” дууны бичвэртэй харьцуулж үзвэл тус дуу бүрэн биш гэдэг нь мэдэгдэж байна.

Хорчины “Гоо Шио Жэй” гэх дууны үйл явдал нь Чимэг бүсгүй үзэсгэлэнтэй залуу бүсгүй Гоо Шио Жэйг магтан дуулж эхэлдэг бөгөөд хариуд нь Тэй Жү (ах, найз хэн нь тодорхойгүй),

Эрдэнэ гардийн зулзаган чинь ичээнээсээ гарав хүй

Эцэг тэнгэр огторгуйдаа өөрийн дураараа ниснэ хүй

Энхрий бага Гоо Шио Жэй арван ес наслав аа хүй

Энгэр, арын залуучуудыг үймүүлж байна тэр чинь хүй

хэмээн сануулна. Чимгийн нөхөр нь залуу бүсгүй Гоо Шио Жэй-д дурлаж биднийг салшгүй эр эм болгооч хэмээн хүсэн залбирах аж.

Чимэг бүсгүй нөхрөө хардаж “унасан морь чинь хөлстэй, үүрсэн буу чинь байхгүй байна, Гоо Шио Жэйд очоод ирээ юу” гэхэд нөхөр нь “ан гөрөөнд явсан,

<sup>12</sup> Стивен Карпман (1968) “зөрчилдөөний гурвалжин” гэхээс илүү “драмын гурвалжин” гэсэн нэр томъёог сонгон “Fairytale and script drama analysis” (Үлгэр ба найруулгын дүн шинжилгээ) гэх өгүүлэлдээ “Улаан малгайт” үлгэрийн үйл явдалд тулгуурлан драмын гурвалжны онолоо анх бичиж тайлбарласан.

багшдаа буугаа үлдээсэн” гэх мэтээр булзааруулах гэж оролдоно. Энэ байдлыг мэдэх Тэй Жү, нөхөрт нь хандан журмын эхнэр чинь чамайг хайрлаж байгаа гээд,

Аюулхайгаас гарсан үрээ бодвол хүй  
Арын айлын Гоо Шио Жэйд очихоо цөөчилнө дөө хүй  
...Зүрхнээс гарсан хоёрхон үрээ бодвол аа хүй

Зүүн айлын Гоо Шио Жэйд очихоо цөөчилнө дөө хүй хэмээн гуйна.

Байдал улам ээдрээтэй болж Чимэг бүсгүй, нөхрөө Гоо Шио Жэйд очуулахгүй гэж арга барна. Харин Гоо Шио Жэй бүсгүй “Жийжүү хот” дууны Бянуу хүүхний адил,

Агт хүлэг морио хүчрэхгүй бол хүй  
Адууныхаа дунд нь эмээлийг нь аваад тавихгүй юу хүй  
Авсан эхнэр Чимэгээ хүчрэхгүй бол хүй  
Анхны ирсэн замаараа харьчих чи минь хүй...хэмээн гомдоллоно.

Эцэст нь, Чимэгийн нөхөр Тэй Жүгийн үг зөв болохыг ухаарч,

Гурав дөрвөн ах дүү хэдий арвин байвч хүй

Голдоо санасан Тиян зу гэ гэгэг гүйцэх гэнэ үү дээ хүй... гэж дуулахад

Тэй Жү түүний амьдрал нь нурж уруудаж байгааг,

Ар ч хашаа чинь урагшаа нураад байна хүй

Аавын хураасан буян хишиг чинь буурахын тэмдэг ба хүй

Арын Гоо Шио Жэйд өдөр өдөр гүйж байна хүй

Аавын буян адуу мал чинь сүйдэж барахын тэмдэг ба хүй (Хорчин

ардын дуу, 1987, 7-10) гэхчлэн сануулж байгаагаар төгсөнө.

Эндээс “Жийжүү хот” дууны зөрчил шийдвэрлэгдээгүй буюу үйл явдал дутуу мэт байдлыг аврагч Тэй жүгийн дүр нөхөж байна.

Дээрх дуунуудын дүрийг Карпманы драмын гурвалжинд байрлуулж үзвэл,

Зураг 2. “Жийжүү хот” болон “Гоо Шио Жэй” дууны дүрийн гурвалжин



Драмын гурвалжны онолоор харилцан хамааралтай гурван дүрийн үүрэг тодорхой бөгөөд хохирогчид буюу “Жийжүү хот” дууны Дэнзья, “Гоо Шио Жэй” дууны Чимэг нар бүсгүй хүний хувьд ихээхэн хохирол амсаж байгаа ч дотроо шаналж, тэр шаналаа үйл урлан тайлж байхад нөгөө нь уурлаж, уйлж загнаж, буруу гэдгийг илчилж байна. Эдгээрийн аль аль нь сайн, муу үр дагаварт хүргэх талтай. Тухайлбал, Дэнз’яа бүсгүйн дуулж буй хэсэгт “Баруун голын усанд очье гэтэл банз модоор дамнуурга тавьсан, Зүүн голын усанд очье гэсэн чинь зүсмэл банзаар дамнуурга тавьсан” гэж дурдаж байгаа нь ганцаардан зовсон бүсгүйн

сэтгэлийг илэрхийлж, гомдолтой айдастай байгаа нь хохирогч мөн гэдгийг харуулна. Харин Чимэг нөхөртөө хандаж сайхан хүүхэн рүү яваад байхын оронд “Ар хаяанд хутга байна зүрх рүү минь чиччих” гэж хэлнэ. Онолын хувьд Чимэгийн нөхөр ч, Гоо Шио Жэй ч хохирогч болж болно.

“Хохироогч” тал олон байгаа бөгөөд Бянуу, Гоо Шио Жэй нар бол хувиа хичээсэн, түр зуурын давуу байдлаа хадгалах эрмэлзэлтэй, сэтгэлээр унах, гутралаас зайлсхийхийн тулд эхнэр болоод хүүхэд, унаа морийг ч хайрлахгүй бүсгүй хүнээс гарамгүй харгис зан гаргаж байгааг зэрэгцүүлж үзвэл үгийн хувьд нэлээд төстэй байгаа нь анхаарал татаж байна.

*Хүснэгт 1. Бянуу, Гоо Шио Жэй нарын дууны хэсэг*

“Жийжүү хот” дууны Бянуу	“Гоо Шио Жэй” дууны Гоо Шио Жэй
Үрээморь чинь үргэж булгиад байвал Өртөөнд бариад өгчихгүй юу, Өөрийн эхнэр Дэнз’яа чинь уурлаж загнаад байвал Өвдөглөж байгаад зодохгүй юу, түүнийгээ (Оюун, 1960: 14)	Үрээ хүлэг морио хүчрэхгүй бол хүй Өмнө талдаа очоод эмээлийг нь аваад тавихгүй юу хүй Өөрийн эхнэр Чимэгээ хүчрэхгүй бол хүй Урьдын ирсэн замаараа эргэчих чи минь хүй

Хохироогчдын дүр өнөөдөр ч амьдралд байсаар байгаа бөгөөд дашрамд дурдахад, заримтүүвэрт энэ мэт үгийг хассан нь үзэл суртал, муугийн нөлөөллийг бодолцсон байж мэднэ.

“Аврагч” нь хохирч байгаа талыг ойлгож туслагч, халамжлагч, зөв шударга дүртэй ч заримдаа дүрээ далдалсан хуурамч буянтан байж болдог. Аврагчийн дүр тодорхой байгаа “Гоо Шио Жэй” дуунд Тэй Жү, Чимэг бүсгүй болон хүүхдүүд хохирогч болохоос сэргийлж тэдэнд урьдчилан хэлж сануулж, зөвлөнө.

Энэчлэн “Жийжүү хот”, “Гоо Шио Жэй” дууны үйл явдал, дүрийг хөөж үзвэл төстэй шинж байгаа нь монгол ардын богино дууны хэв шинж байж болох ч харилцаа дуу, дуулалт жүжиг хөгжих эх суурь болсон ганц аятай, нэг хүний жүжиглэж дуулдаг тийм хэлбэрийн дуу байсан байжээ гэсэн санаа дэвшүүлж байна. Олонх дууны эмхэтгэлд дүрүүдийг харилцаа дуу шиг тодорхой бичээгүй, богино хугацаанд түргэн өрнөдөг, хурц тод үйл явдалтай бөгөөд хэрэв харилцаа дуу байсан бол дүрүүд тус тусын аятай ч байх байсан биз ээ.

Дэнз’яа ганцаардахгүйн тулд элдэв зүйл дүрсийг шаглан<sup>13</sup> оёж байх мэт. Хатгамал нь монголчуудын урлахуйн чухал төрөл бөгөөд аз жаргал, сайн сайхны төлөө соёлыг илэрхийлэл болдог.

“Жийжүү хот” дууны бичвэрт олон тооны эд зүйл (артефакт) Дэнз’яа бүсгүйн хатгамалд дүрслэгдэж байгаа нь бидний ажиглалтын нэг хэсэг нь юм. Бид тус дууны бичвэрээс Жийжүү хот, жинтүү, байшин зэрэг соёлын артефактуудад утгазүйн тайлбар хийлээ.

Дуунд,

Жийжүү хотын жинтэйхэн торгоор хө хө

<sup>13</sup> Шаглах оёо бол оёдол, хатгамлын суурь бөгөөд жигд нэвтгэлзэн хатгаж гэмнэнэ оёдол цэвэр, уран байдлыг илэрхийлнэ.

Жинтүүний буланг шаглад оёсон юмаа хө хө...  
Урт газрын ухаа ягаан торгоор хөө хө  
Уутны буланг шаглад оёсон юмаа хө хө  
гэх буюу  
Цагаан жигүүртэй тахиа шувууг  
Цааш, нааш нь харуулж байгаад шаглад оёсон юм ...  
Улаан жигүүртэй тахиа шувууг  
Урагш, хойшоо донгодог байгаагаар шагнаад оёсон юм (Дашзэвэг, 1998: 136)  
гэж эхэлдэг.

Жийжүү хотны талаар судлаачид “Бээжин Тяньжин хоёрын дунд байдаг Тяньжины харьяа Жи шянь хот. Эхэн үедээ Жи шянь-ийг Жийжүү хот хэмээн нэрлэж байсан” Мөнхтөр, 2017 оны 3 сарын 3) гэхчлэн үзжээ. Зарим тайлбар тольд “Өмнөд хятадын Жий-жоу хот гэж байсан нь тааралдана.

Бидний үзэхээр, Жийжүү хот гэдэг нь монголчуудын дунд Янжин (*Yanjing*) нэрээр алдаршсан Жи (Ji) буюу Жи чэн (Jicheng) болов уу гэж үзэж байна. Тус хот нь өнөөгийн Бээжин хотын баруун өмнөд хэсэгт МТӨ 1045 онд Жоу гүрний үед байгуулагдсан байгаад улс, мужийн нийслэл, Таван улсын үед муж зэрэг статустай байсаар өдгөө Бээжин хотын умард дүүрэг болжээ.

**Жийжүү хот**-Монгол хэлний тайлбартольд “Жий жоу” гэж дурдсан бол “Жи Жөү (Жөү) гэж тухайн үеийн Манж болоод Хятадын засаг захиргааны нэгж болох (тойрог) буюу тэр цагийн засаг захиргааны нэгжийн нэр юм. Тэр (тойрог) бүс нутаг нь тус төмөр боловсруулах ур хийц, урлагаараа алдартай учир монголчлоод Жийжүү дөрөө, жийжүүдэх гэх нэр томъёо гарсан бололтой” (Ariunbold Altanhuuag-ийн тайлбар) гэсэн санал бий. Бидний саналаар Жи гэх хот-улстай холбон үзэж байна. Жи улс нь Шан гүрний үед Шар хааны овог аймаг байж байгаад Жоу гүрний үүсгэн байгуулагч вассал улсуудын нэг болжээ. Тэр цагаас Жижоу буюу монгол хэлнээ Жийжүү гэх болсон бололтой. Тус хот Ляо гүрний үед (907-1125) Нанжин хот гэж байгаад монголчуудад эзлэгдэн Янжин гэх болжээ. Түүхийн бүтээлүүдэд Цинь гүрний үед Жи нь Монгол, Манжууртай холбосон замын зангилаа болж байсан ([BTVU](#), “[屏障中原的军事重镇](#)” дам эш) гэдгийг тэмдэглэсэн байдаг. Тиймээс уг дуу нэн эрт үеийн хот балгадын нэрийг хадгалж байгаа нь хожуу үеийн дуу бус гэдгийг харуулах мэт.

Зураг 3. Юань улсын нийслэл Жи хот



Эх сурвалж. Юань улсын үеийн газрын зураг

<https://www.bing.com/images/search?view>

**Жинтүү** гэх үгийн гарлыг доктор О.Сүхбаатар “хятад.zhên tou...гээд” (Сүхбаатар, 1997: 104) хятад гаралтай үг гэсэн ба жинтүү, дэр нь ариун нандин зүйл, гэр бүлийн бат бөх байдлыг бэлгэддэг.

Монгол хүн толгойгоо ихэд эрхэмлэх тул тэргүүнээ тавьж амарч унтах дэрээ хамаа бус хаядаггүй, цэвэр байлгаж, эзэн хүнээс өөр хүн гар хүрдэггүй, хүнд өгдөггүй, хүүхдийн хувь заяатай холбоотой байх тул эцэг эх, үр хүүхдийн холбоог харуулдаг ариун эд гэж үздэг. Тиймээс охин үрээ хадамд гаргахад заавал жинтүү бэлтгэн өгч явуулдаг байсан уламжлалтай. Хуримын гол бэлгэдэл болдог тэрхүү дэр нь ойролцоогоор 40 см-ээс дээш урттай буюу хоёр хүний унтах орны өргөний хэмжээнд тохирсон, нүүрэн тал нь дөрвөлжин, элдэв гоёл чимэглэлтэй, нөгөө тал нь мухар булангай, эсгийгээр ширж хийх ба доод талд нь зүсмэл нүхтэй, дэрийг эрхэм нандин зүйлсээр дүүргэнэ. Эсгий дэрний нүүрэн талын булан хялбархан элэгдэж урагдах тул сайтар бөхөлж оёдог бөгөөд жинтүүний буланг сайн оёдог бол сайн оёдолчинд тооцогддог байжээ. Иймд жинтүүний дэр буланг оёж байгаа нь эхнэр, нөхрийн харилцааг бөхлөх утгыг илэрхийлж байна.

Эртний домог зүйд хүний нойр, зүүд бол бурхад, сүнс, үхэгсэдтэй харилцах орон зай болж үйлчилдэг унтах үед хүний сүнс биеэ орхиж явдаг гэх тул оршуулгын зан үйлд дэрийг ашигладаг байсан нь гайхах зүйл биш юм. Монголчуудын эртний оршуулгад үхэгсэдэд чулуу, эмээл дэрлүүлдэг байсан баримтыг археологийн судалгааны бүтээлүүдэд олонтоо дурдсан байдаг.

Эрт үед хятадад хүн 50 нас хүрэхэд хүүхдүүд нь оршуулгад нь бэлдэж эхлэх ба өмсгөх хувцас, тэргүүтний нэг нь дэр ажээ. Дэрийг үхэр зэрэг амьтны эврээр

азарган тахианы хэлбэртэй (鸡鸣枕) хийдэг нь тахиа хүний сүнснийг сэрээнэ гэж үздэг (Исаченкова, 2019: 33), энэ нь ах дүү нартайгаа холбоотой байх, ивээлээ хайрлах, гэр бүлдээ эргэн ирэх зэргийг бэлгэддэг, харин бар хэлбэртэй хийх юм уу хатгаж оёвол муу зүүднээс сэргийлдэг, харин баавгай бол сайн хүүтэй болохыг тус тус бэлгэддэг байжээ. Тийм ч учраас дэр жинтүү бол үнэнч ариун, үр хүүхэд олонтой байдлыг урладаг гэр бүлийн уламжлал бүхий ахуйн соёл юм.

**Байшин** бол консерватив соёлын объектуудын нэг бөгөөд түүнийг дүрсэлж зурж, урлахын утгыг психоанализыг үндэслэгч З.Фрейд байшинг хүний биетэй адилтган үздэг эртний ойлголт гэж тайлбарласан байдаг (Фрейд, 1989: 147)

Домог зүйд байшингийн бэлгэдлийн агуулга нь далд мөртөө ил зүйлийг төлөөлдөг, голомт гэсэн утгатай хэмээн тайлбарладаг тул Дэнзьяа бүсгүй “жин байшин, луу байшин” хоёрыг урлаж байгаа нь гэр бүлээ хамгаалах сэтгэлийг илэрхийлэх мэт. “Гэр бол хүнийг ямар нэг зорилготой ашиглахаас хамгаалдаг хил хязгаар юм. Энэ нь ашиг тустай байдлыг сольж, эрэмбэлэх хууль үйлчилдэггүй тийм газар юм” гэсэн үг бий (Дом, 1997, № 10. С. 10-29).

*Жин* байшин (жинь гэж бичсэн байх нь бий) гэх үгийн жин гэдэг үгийн тайлбар янз бүр байна. Тухайлбал, Жин улс бол Зүрчдийн Алтан улсыг зааж байж. Мөн юмны хүнд хөнгөнийг заах утга байдаг. Судлаач Л.Мөнхтөр жин гэх үгийг алт гээд “Алтан дээвэртэй байшин, луун хээтэй байшин” гэсэн утгаар орсон гэж үзсэн байдаг.

Бидний үзэхээр, жин бус жан гэсэн үг ажээ. Толь бичигт “ЖАН I хя. zháng... Арван тохойтой тэнцүү ургын хэмжээ. Урт, өргөн, гүний хэмжээ, хос алд буюу 10 чий, 3,2 метр. Жан жангийн таван өнгийн хадаг... (С.Д)” гэснээс гадна “ЖАН IV jiāng. Байшин барилгын өрөө тасалгаа? гурван жан өрөө, гучин жан хашаа” (Сүхбаатар, 1997: 99) гэж тайлбарласан байна. Тиймээс жангийн байшин (Сэцэн ханы Алтан жан ордон), гурван жан худаг гэх мэт ярьдаг төдийгүй монгол оньсогод,

Нэг жан байшин (жил)

Дөрвөн хаалгатай (улирал)

Арван хоёр цонхтой (сар)

Гурван зуун жаран хадаастай (хоног)

гэх бол “Жин торго захгүй, жижиг сувд нүхгүй”

гэх мэтээр ярианы явцад шүлгийн үеийн авианы нөлөө, нутгийн аялгуу зэргийн улмаас жин торго, жин байшин гэх болсон бололтой.

Харин **жинтэй торго** гэвэл өөр утгатай болно. Хятад хэлний 锦 гэдэг нь (хээтэй торго, угалзан хээтэй торгомсог бөс) гэсэн ерөнхий утгатай ч 7-8-р зууны эхэн хүртэл Хятадын торгоны үйлдвэрлэлд өргөн ашиглагдаж байсан гурав, тав, долоон утасны сүлжих замаар S хэлбэртэй, зургаан өнцөгт зэрэг геометрийн дүрст бүхий нэлээд төвөгтэй нэхмэл хээтэй торгон болон торгомсог даавууг нэрлэдэг байна. Дайтагч улсуудын үед (МТӨ 475-221 он) Шу хэмээн нэрлэгдэж байсан Сычуаны нутагт анх үүсжээ. Хань гүрний үед эрчимтэй хөгжлийг олж Торгон замын гол бараа болж Азид мориор арилжиж байжээ. Тан болон Сүн гүрний үед (618-1279 он) жин торго оргилдоо хүрч нэхэх техник улам боловсронгуй болж яруу найрагчид түүний сайхныг шүлэгтээ тэмдэглэж, хээ угалз гайхмаар нарийн,

уран сайхны чанарыг олжээ. Тиймээс жин торго хаад язгууртны амьдралын чухал эдлэл, тэр цагийн хүмүүсийг эрх мэдэл, эд баялаг, эрх тушаалын бэлгэдэл болжээ.

Зураг 4.



Эх сурвалж. 锦行天下：中国织锦文化展 - 每日环球展览

Мин, Чин гүрний үед жин торгонд өөр торго дурдан, үслэг бөс өрсөлдөн гарч ирсэн ч илүү гүн агуулгатай болж онцгой бэлгэдэлт зүйлсийг дүрслэх болжээ. Чухамхүү энэ цагт тогоруу, нар, ус, үүл зэрэг найман бэлгэдэлд бүхий бөс гэгдэж эхэлжээ.

Зураг 5.



Эх сурвалж. 锦行天下：中国织锦文化展 - 每日环球展览

**Дамнуурга (гүүр)** гэх үгийг Дэнзьяа бүсгүй нөхрөө санагалзан дуулдаг. Гүүр болон дамнуургыг бэлгэдэл зүйн үүднээс авч үзвэл, а) хил зааг, б) холбоо харилцаа, в) уулзах болзох газар, г) эргэцүүлэх, зарим тохиолдолд амьдралыг шийдвэрлэх цэг, д) бүтээмжийн бэлгэдэл зэргээр тайлбарлагдана. Тухайлбал, аман зохиолын зүйл, хожим зохиол бүтээл, урлагт гүүрэн дээр баатар эр юм уу залуу эр, гүнж, хайртай бүсгүйгэйгээ удаан хугацааны дараа гүүрэн дээр болзож уулзах ба энэ тохиолдолд гүүр хоёр ертөнцийн хил хязгаар, шинэ чанарт шилжих, шинэ амьдралын эхлэлийг бэлгэдэх бол бүхэлдээ нэг ертөнцөөс нөгөө ертөнцөд нэвтрэх шилжилтийн утга агуулдаг. Учир нь гүүрэн дээрх уулзалт бол жирийн уулзалт байдаггүй. Нөгөө талаар гүүр бол найдвар, бат бөх байдлыг бэлгэддэг бол дамнуурга хэврэг зүйлийг төлөөлжээ. Тийм ч учраас Дэнзьяа бүсгүй гол руу яваагүй гэртээ хатгамал хийн суух ажээ.

“Жийжүү хот” дууны агуулга, шүлгийн зарим үгэнд тайлбар хийхэд дээрх мэтээр олон сонирхолтой зүйлс тодорч байна. Харин аялгууг нь шинжилбэл Гэсэрийн тахилгын аянд тааруулж зохиосон гэх таамаглал тодорхой болох буй за. Дуунд Цагаан царайтай Цасчихэр, Улаа бутарсан Гэсэр мэргэн баатрыг урласан гэж байгаа нь Дэнзьяа бүсгүй сэтгэл санаагаа тайвшруулах эрмэлзлээс илүү ямар нэг “аврагч”-ийг эрэлхийлж байх мэт.

Баатар хүнийг дүрслэх гэдэг, *нэгд*, ялангуяа туулийн баатар гэдэг домог зүйн дүр болдог, *хоёрт*, амьд хүмүүсийн тусгал бөгөөд бүхэлдээ хүч чадал, зориг, энэрэнгүй уужим сэтгэл, шударга ёс зэрэг төгс эр хүний бэлгэдэл болдог тул тус дуунд үнэний төлөө, ялалтын төлөө тэмцэгчийг сонгон тэдгээрийг нааш, цааш, урагш хойш харж байгаагаар амьд мэт хатгаж оёсон гэж өгүүлжээ. Энэчлэн тус дуун дахь Дэнзьяа бүсгүйн Утай, Бээжин тагшин таван орон, зүр гурын зөрөлдүүлэн, тахиа шувууг цааш нааш харуулан, донгодож байгаагаар урласан зүйлсийг нэмэн дэлгэрүүлж болох юм.

## Дүгнэлт

Монгол ардын богино дууны дотор Гэсэр богдын тухай өгүүлсэн, дурдсан дуу үндсэндээ энэхүү “Жийжүү хот” хэмээх дуу юм. Тус дууны үүсэл, домог, түүх Гэсэрийн тахилгатай ямар нэг байдлаар холбогдох тухай санал бий боловч баттай биш байна. Тиймээс уг дууны шүлэг дэх зарим дуунд тайлбар хийхэд нэлээд эртний түүх, соёлыг агуулсан хэдий ч түүхэн дуу биш, харин түүхэн сэдэвт дуунд хамаарна.

Дууны хувилбарууд, бичвэрт илэрч байгаа агуулга, үгсийн бүрэлдэхүүн, артефактын дүрслэлийн семиотик утга, бэлгэдэл, зөрчилт үйл явдал зэргээс хайр сэтгэлийн гурвалжны зөрчлийг илэрхийлэх драмлаг дуу гэж үзэж байна. Тиймээс тус дуу нь өнөөгийн Архангай аймгийн нутаг дахь Тариат уулын бэл дэх Далай Чойнхор вангийн хүрээнээс гаралтай гэдэг домог эргэлзээ төрүүлж байгаа бөгөөд судлаач Б.Буянзаяа, Б.Гэрэлмаанар Тариат сумын нутагт байсан Гэсэрийн сүмийн лам нарын бүртгэлийг шүүж үзээд тахилч Гүнтэв гэдэг лам байхгүй байсныг дурдсан бий (Буянзаяа нар, 2023: 280).

«Жийжүү хот», «Гоо Шио Жэй» дууны үг хэллэг, зохиомж төстэй, Карпманы гурвалжны онолоор авч үзвэл суурин иргэншлийн нөлөө бүхий, харилцаа дууны хөгжлийн урьтал, ганц дуучин жүжиглэн дуулдаг дуу гэж үзэж байна. Тийм ч

учраас судлаачид “Жийжүү хот” дууг богино, харилцаа, хошин зэргээр олон төрөлд хамааруулж үздэг.

“Жийжүү хот” дууны бичвэрт илэрч байгаа артефактаар дамжуулан дүрүүдийн сэтгэлзүй, монгол хүний далд ухамсар, бэлгэдлийн олон утгыг тайлах нь буруу, дутуу дуулах, дууны утгаа бүрэн гүйцэд ухаарах зэрэгт хэрэгцээтэй гүнзгийрүүлж болох судалгааны өргөн боломж юм.

### Ном зүй

- Оюун, Э.** (1960). Монгол ардын харилцаа дууны зүйлээс. “*Монголын судлал*”, Tomus I, Fasc. 6, Улаанбаатар: ШУАХ. [Oyun, E. Mongol ardyn khariltsaa duuny züilees. Mongolian studies, Tomus I, Fasc. 6, Ulaanbaatar, PMAС: 1960.]
- Ринчэнсамбуу, Г.** (1959). Монгол ардын дууны төрөл зүйл. “*Монголын судлал*”, Tomus I, Fasc. 26, Улаанбаатар: ШУАХ., [Rinchinsambuu, G. Mongol ardin duuni turul zuil. “Mongolian studies”, Tomus I, Fasc. 26, Erdem Shinjhlgeeenii Kheveleliin Gazar, PMAС: Ulaanbaatar, 1959.]
- “Монгол дуунууд, аялгууны нотын хамт”** (2020). Эрдэнийн очир цуврал-2. Удиртгал тайлбар бичиж хэвлэлд бэлдсэн С.Түвдэндорж, Монгол бичгээс кирилл үсэгт буулгасан Ч.Дүүжий, редактор Б.Түвшинтөгс. “Мөнхийн үсэг” ХХК. [Mongol duunuud, ayalguuny notyn khamt. Erdeniin ochir series-2. Preface and commentary prepared for publication by S. Tuvdendorj, transliterated from Mongolian script into Cyrillic script by Ch. Dujii, editor B. Tuvshintugs. Ulaanbaatar, “Mönkhin süf” LLC: 2020.]
- Фрейд З.** (1989). *Введение в психоанализ: Лекции*. М.: Наука, 1989. 456 с. Дом. *Материалы заочного круглого стола* (выступление В. М. Литвинского) // Ступени. Философский журнал. 1997. № 10. С. 10–29. [Freud Z. Introduction to Psychoanalysis: Lectures. Moscow: Nauka, 1989. -456p. Home. Materials from the Correspondence Round Table (presentation by V. M. Litvinsky) // Steps. Philosophical Journal. 1997.]
- Исаченкова, М. А.** (2019). *Формирование понятий 神 шэнь и 鬼 гуй в свете бинарных представлений древних китайцев* / М.А. Исаченкова // Традиционная духовная культура восточнославянских и китайского народов. Гомель, ГГУ им Ф. Скорины, С. 91–96. [Isachenkova, M. A. Formirovaniye ponyatiy 神 shén shen'i 鬼 guǐ guy v svete binarykh predstavleniy drevnikh kitaytsev /M.A. Isachenkova //Traditsionnaya dukhovnaya kul'tura vostochnoslavyanskikh i kitayskogo narodov. GomeI', GGU im F. Skoriny: 2019.]
- “Цагаан дар эхийн тууж”** (1991) Монгол бичгээс кириллд буулгасан Ц.Сүхбаатар. Хянан тохиолдуулсан Г.Нямаа, Г.Буянтогтох. УБ., ШУХГ.[“Tsagaan dar ekhiin tuuj”. Mongol bichgees Kirill Buulgasan Ts.Sukhbaatar. Ed. G.Nyamaa, G.Buyantogtokh. Ulaanbaatar, SHUNG. 1991.]
- “Хорчин ардын дуу”** (1987). Эмхэтгэсэн Өлзийсан., Сэцэнгуа. Өвөр Монголын “Монгол тулгуур бичгийн цуврал” (Аман зохиол) II боть. Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо. -514х. [“Khorchin ardyn duu”. Emkhetgesen Olziisan., Setsengua. Uvur mongolin “Mongol tulguur bichgiin tsuvral” (Folklore) II boti. Uvurmongolin soyolin hevleliin khoroo. 1987.]

Буянзаяа, Б., Гэрэлмаа, Б. (2023) *Жийжүү хот дууны судалгааны зарим асуудал*, (монгол бичгээр). PDF. (14) Б. Буянзаяа, Б. Гэрэлмаа “Жийжүү хот дууны судалгааны зарим асуудал” [Buyanzaya, B., Gerelmaa. “Jijjüü khot duuny sudalgaani zarim asuudal” (original written in Mongolian vertical script). 2023.]



**Open access:** This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>